

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН  
2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТАЛААР  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 11 дүгээр  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Уг асуудлыг Байнгын хороо 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, М.Батчимэг нарын гаргасан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблейн хурал 2015 онд Улаанбаатар хотноо зохион байгуулахтай холбогдуулан урсгал төсвийг 868.1 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төсвийг 110.0 сая төгрөгөөр (нийт 978.1 сая төгрөг) тус тус тооцож Улсын Их Хурлын төсвийг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, М.Батчимэг нарын гаргасан Монгол Улсад 2016 онд зохион байгуулагдах Ази, Европын дээд хэмжээний уулзалт /ACEM/-ын бэлтгэл ажлыг хангахад зориулан 47.0 тэрбум төгрөгийг төсвийн зохих хэсэгт нэмж тусгах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжив.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын Улсын Их Хурлын Тамгын газрын тэтгэврийн насанд хүрч, төрийн албанаас чөлөөлөгдөх ажилтнуудад Төрийн албаны тухай хуулийн дагуу 36 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоход зориулан 183.5 сая төгрөгийг нэмж тусгах, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж. Л.Цог нарын Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийг тохиолдуулан Үндсэн хуулийн 20 жилийн ойн үед орон сууцны дэмжлэг үзүүлэх арга хэмжээнээс хоцорсон Улсын Бага Хурлын нэр бүхий 13 гишүүн, тэдний ар гэрт орон сууцны дэмжлэг үзүүлэхэд 910.0 сая төгрөгийг төсөвт нэмж тусгахаар гаргасан саналуудыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, М.Энхболд, Сү.Батболд, Сү.Батболд, Ч.Хүрэлбаатар нарын гаргасан онцгой байдал, эрүүл мэнд, цагдаагийн байгууллагаас бусад төрийн өмчит болон төсвийн байгууллагуудын шатахууны зардлыг 30 хувиар танах санал гишүүдийн олонхын дэмжлэг авсан бөгөөд үүнтэй холбогдуулан батлан хамгаалах, хил хамгаалах байгууллагуудын шатахууны зардлыг бууруулж болох эсэхийг анхаарах нь зүйтэй гэж Байнгын хорооны гишүүд үзлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, М.Энхболд, Сү.Батболд, Сү.Батболд, Ч.Хүрэлбаатар нарын гаргасан төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын орон тоог 10 хувиар бууруулах санал Байнгын хорооны хуралдаанаар

дэмжигдээгүй бөгөөд уг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн Сү.Батболд цөөнх болов.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүдээс олон улсын томоохон хэмжээний хурал зохион байгуулах төвийн барилга барих асуудлыг судлан яаралтай шийдвэрлэх, АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хариуцах чиг үүрэг бүхий бүтэц бий болгох, уг арга хэмжээний товыг аль болох тохиромжтой үеийг сонгон тогтооход анхаарах, хувийн хэвшлийг татан оролцуулах, Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт, зорилтот түвшинг бодитой төлөвлөсөн эсэхийг нягтлах, засгийн газрын болон агентлагуудын оновчтой бүтэц бүрдүүлэх, төрийн албыг шинэчлэх талаар тодорхой ажил зохион байгуулах, хөрөнгө оруулалтын төсвийн менежментийг сайжруулах зэрэг саналууд гаргасныг Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгах нь зүйтэй гэж үзлээ.

Төсвийн байнгын хорооны хуралдаанд тус Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүнд Д.Эрдэнэбат танилцуулахаар тогтов.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийн талаар тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн, шийдвэрлэж өгөхийг хүсье.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН  
2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг. Байнгын хорооны дэмжсэн санал:**

1. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблейн хурлыг 2015 онд Улаанбаатар хотод зохион байгуулахтай холбогдуулан Улсын Их Хурлын урсгал төсвийг 868.1 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төсвийг 110.0 сая төгрөг (нийт 978.1 сая төгрөг)-өөр тус тус нэмэгдүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, М.Батчимэг**

2. Тэтгэврийн насанд хүрч, төрийн албанаас чөлөөлөгдөх ажилтнуудад Төрийн албаны тухай хуулийн дагуу 36 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоход зориулан 183.5 сая төгрөгийг Улсын Их Хурлын Тамгын газрын төсөвт нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат**

3. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 1.2.2-т заасан 240.0 сая төгрөгийн зардлыг хөрөнгө оруулалтын төсвөөс хасаж, Улсын Их Хурлын 2015 оны төсвийн урсгал зардалд шилжүүлэн тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа**

4. Төрийн өмчит болон төсвийн байгууллагуудын шатахууны зардлыг 30 хувиар хэмнэх (онцгой байдал, эрүүл мэнд, цагдаагийн байгууллагаас бусад)

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, М.Энхболд,  
Сү.Батболд, Сү.Батболд, Ч.Хүрэлбаатар**

5. Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийг тохиолдуулан Үндсэн хуулийн 20 жилийн ойн үед орон сууцны дэмжлэг үзүүлэх арга хэмжээнээс хоцорсон Улсын Бага Хурлын нэр бүхий 13 гишүүн, тэдний ар гэрт орон сууцны дэмжлэг үзүүлэхэд 910 сая төгрөгийг төсөвт нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж. Л.Цог**

6. 2016 оны АСЕМ-ын арга хэмжээний бэлтгэл ажлын төсөв 47 тэрбум төгрөгийг төсөвт нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, М.Батчимэг**

**Хоёр. Байнгын хорооны дэмжээгүй санал:**

**1. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын орон тоог 10 хувиар бууруулах.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, М.Энхболд,  
Сү.Батболд, Сү.Батболд, Ч.Хүрэлбаатар  
Цөөнх: Улсын Их Хурлын гишүүн Сү.Батболд**

-----ооо-----